



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/362

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25, 31 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын шийдвэрээр данс бүртгэлээс хасагдаж, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэгдсэн эд хөрөнгийг худалдан борлуулах үнийг тогтоох, худалдах боломжгүй хөрөнгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар өөрчлөн байгуулсугай.

2.Данснаас хасч татан төвлөрүүлсэн хөрөнгийг худалдан борлуулах, худалдах боломжгүй хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах ажлыг зохион байгуулж, үнэлгээг зохих хууль журмын дагуу хийж, тайланг улирал бүр танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/87 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



М.БАЯРАА

**115050001013**

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2021 оны 10... дугаар сарын 28... -ны өдрийн  
А/362 дугаар тушаалын хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Болор-Эрдэнэ

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Батбаяр

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Ж.Сувданзаяа

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Мөнгөнхүү

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Төрболд

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн

Г.Нямбаяр

Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн менежер

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Н.Цэцэгдэлгэр

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн